

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 13б, Утас: 7012-8801,
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
<http://www.chd.mohs.mn>

2019.06.27 № 966
таний -ны № -т

Г Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх

Тус төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас өгсөн 3 зөвлөмжийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үндэсний аудитын газраас Үйл ажиллагааны орлогыг үйлчилгээ үзүүлсэн нэр төрлөөр ангилан бүртгээгүй, тус төвийн 2 дугаар байрны байрлагчдын бүртгэлийг тодорхой бус бүртгэсэн, түүнд тавих хяналт сул байгаа талаар өгсөн зөвлөмжийн чиглэлээр хийсэн ажил:

- Тус төвийн үндсэн үйл ажиллагааны орлого болох Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтын орлогыг үзүүлсэн үйлчилгээний нэр төрлөөр нь тарифын дагуу ангилан бүртгэж байна.
- Байрлагчдын бүртгэлийг сайжруулж байрлагчдыг овог нэр, нас хүйс, регистрийн дугаар, иргэний харьялал, гэрээний огноо, дугаар, орсон гарсан хугацаа, хэдэн тоот өрөөнд ямар хугацаатай байрлах, аль аймгаас ямар мэргэжлээр ямар хугацаатай суралцаж байгаа зэргээр нь дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

2. Дотоод хяналт, санхүү, захиргааны албаны даргын үүргийг нэг албан тушаалтан гүйцэтгэж байгаагаас санхүүгийн хяналт супарсан, байгууллагын хяналтын хараат бус байдал алдагдсан тухай зөвлөмжийн чиглэлээр хийсэн ажил:

- Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний ажлын байранд мэдээллийн хэрэгслээр ажилд авах тухай зар тавьсан боловч зарын дагуу ажилд орох хүсэлтэй иргэд ирээгүй тул байгууллагын ажилтан, албан хаагчдаас тухайн ажлын байранд тохигох хүнийг Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311, 2015 оны 483 дугаар тогтоолыг тус тус үндэслэн төсөв захирагчийн дэргэд үндсэн ажилтны орон тоонд багтаан томилон ажиллуулж байна.

4. ЭМХТ-ийн хөрөнгө шинээр бэлтгэх тушаалын үндэслэл буруу тушаалаар 12.324.4 мянга, төсөв захирагчийн тушаал шийдвэргүй 71.980.6 мянга буюу нийт 84.305.0 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэхдээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр бэлтгэсэн тухай өгсөн зөвлөмжийн дагуу хийсэн ажил:

- 2019 оны 03 сарын 11-ний өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт “Зөвшөөрөл хүсэх тухай” 278 дугаар албан бичгээр тус төвийн 2019 оны батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хүргүүлсэн. Тус газраас 2019 оны 3 дугаар сарын 22-ны A-5/776 тоот албан бичгээр зөвшөөрлийг авч хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, данс бүртгэлд тусган ажиллаж байна.

Аудитын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн биелэлт(....хуудас)-ийг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Д.ГАНЦЭЦЭГ



УХА0456 9086331